

Орчин үеийн орчуулгазүйн чиг хандлага хийгээд

Монголын орчуулгазүй

Ш.Эгшиг /МУИС, ГХСС/

Түлхүүр үг: *орчуулгазүй, орчуулгын онол-дадал, Жеймс Холмсын орчуулгазүйн судлахууны бүтцийн зураг, Р. Якобсон*

Орчуулгазүйн хөгжлийн дэлхийн хандлага

Бид бүхий л салбартаа дэлхийн хөгжилтэй мөр зэрэгцэн хөл нийлүүлэн хөгжих гэж мэрийцгээдэг. Дэлхийн хөгжилтэй орны иргэд шиг ихэнх айл өрх унаатай, хүн бүр гар утастай, зарим хүн өөр өөр сүлжээний хэдэн утастай ч байх болжээ. Үүнтэй адил шинжлэх ухааны салбарт судалгаа шинжилгээ хийх арга барил, аргазүйд ч мөн дэвшил гарч байгаа юм. Анагаах ухааны салбарт гэхэд сүүлийн үед гадаадад хийдэг мэс заслыг ч эх орондоо хийдэг болсоор байгаа билээ. Мөнөөхөн иймэрхүү үйл явцын нэг нь нэгэн үе унаад байсан орчуулгын зах зээл эдүгээ хамгийн ихээр сэргэсэн гэхэд болно. Сайн муу олон орчуулга гарч, харин орчуулгыг цэгцлэх цаг болсон байна.

Орчуулга хийх хийгээд хэлмэрчлэх үйл явц нь хүний эх хэл ба эзэмшсэн гадаад хэлний дадлаар хийдэг ажил билээ. Гэхдээ дадлаар хийдэг ажил ч гэсэн алхам тутамдаа орчуулж буй агуулгад хамаарах салбарын мэдлэг шаарддаг, хэлшинжлэлийн онолын асуудлыг дадалд ашиглан, хэлний дүрмийн дагуу хийдэг ажил юм. Энэ бол орчуулга ба хэлмэрчлэхүйн нэг тал бөгөөд харин нөгөө тал нь орчуулж буй болон хэлмэрчилж буй зүйлийг зохиогчийн ба хэлэгч этгээдийн цаад гаргаж гэж буй санаа ба сэтгэл хөдлөлийг тухайн хэлээр дамжих соёлын утгатай нь давхар илэрхийлэх үүрэг бас бий. Орчуулгазүй бол эдгээр асуудлыг судалдаг ухаан юм хэмээн хамгийн энгийнээр тайлбарлаж болох юм.

Орчуулгазүй буюу орчуулах ба хэлмэрчлэхийг судлах ухааныг хэлшинжлэлээс ангид авч үзэх аргагүй гэдэгтэй санал нэгдэнэ. Хэлшинжлэл бол орчуулгазүйг багтаасан, хэлийг олон талаас нь судалдаг эртний судлал билээ. Хэлшинжлэлээс олон салбар ухаан бие даан гарсан билээ. Тэгэхээр хэлшинжлэлийн онолын асуудлыг орчуулгазүйгээс ангид үзэх ямар ч аргагүй бөгөөд тэрхүү онолыг нь дадалд хэрэглэх нэгэн бааз талбар нь орчуулгазүй юм. Хэлшинжлэлийн орчин үеийн хөгжлийн хандлагаар орчуулгазүйг тодорхойлж болох хэдий ч орчуулгазүй хэмээх ухаан мөн өөрийн гэсэн онол ба дадлын судалгааны арга, аргазүй, зарчим нь хэдийн бүрэлдэн

тогтсон хийгээд, орчин үеийн техникийн ба сэтгэлгээний хөгжлийн суурин дээр улам бүр хүчээ аван хөгжиж байгаа ерөнхий хандлагыг ажиглаж болно.

Эхлээд, орчуулгазүйн түүхээс товч дурдъя. Энэ ухаан анх үүсэх шалтгаан нь “Яаж орчуулах вэ” гэсэн сэдэл¹ ажээ. Энэ сэдлээс үүсэлтэй асуудал нь орчуулгыг сайн хийхсэн гэдэг хүсэлтэй нэгдэн, эхийг зохиогч, орчуулагч, уншигч гурвын холбоо харилцааны асуудал, эх ба орчуулгын асуудал, улмаар өөр бусад хүмүүс болох орчуулгыг дэмжигч, захиалагч, хэвлэлийн газар орчуулагчдын баг зэргийн санаа зорилго тусах асуудал, орчуулгын эх нь уран зохиолын, аль нэг салбарын шинжлэх ухааны, нарийн мэргэжлийн, энгийн ба аман ярианы, мэдээллийн хэрэгслийн эсэх хийгээд орчуулгын зорилго, аргагүй, арга барил, зарчим гээд олон бусад асуудал нөлөөлж эхлэхээр үүнийг уламжлалт хэлшинжлэлийн онолоор тайлбарлах нь учир дутагдалтай болж иржээ. Ингээд орчуулгазүй шинжлэх ухааны шинжтэй болон бүрэлдсэн үеийг дэлхийн хоёрдугаар дайны дараа өнгөрсөн зууны дунд үед хамааруулан үздэг. Сүүлийн хэдэн арван жил бол орчуулгазүйн хамгийн эрчимтэй хөгжлийн үе гэж хэлэхээр олон шинэ үзэгдэл, бүтээл гарсан, шинэ онолын асуудлуудыг дэвшүүлэн гаргасан үе гэхээр байгаа юм. 1957 онд Парист орчуулгын мэргэжлийн дээд сургууль байгуулагджээ. 1976 онд орчин үеийн хамгийн анхны орчуулгазүйн ухааны доктор тус сургуульд зэрэг хамгаалжээ. Одоогийн байдлаар дэлхийн өнцөг булан бүрт 300 орчим нэр хүнд бүхий орчуулгын мэргэжилтэн бэлддэг сургууль, судалгааны байгууллага байдаг² гэсэн тооцоо байна. Эдгээр нэр хүндтэй байгууллагуудад Монтерейгийн Олон улс судлалын сургууль, Английн Лизийн Их сургууль ба Ворвикийн Их сургууль, Испанийн Барселонагийн Их сургууль, АНУ-ын Луйзианнагийн Их сургуулийн Улсын Хэлмэрчлэхүйн шалгалтын төв, Швейцарийн Женевийн Их сургууль зэргийг нэрлэдэг. Мөн олон улсын холбоо, нийгэмлэгүүд ч олноор буй болсон байдгаас “Олон улсын Орчуулгазүй ба Соёлын нэвчилзүйн нийгэмлэг” одоогоор хамгийн далайцтай үйл ажил явуулдаг (International Association for Translation and Intercultural Studies (IATIS)) байгууллага юм.

Барууны орчуулгазүйн хөгжлийн үе шатыг 3 үед хувааж авч үздэг.

- Эртний уламжлалт судлал болсон Цицероны эртний герег, латин хэлний орчуулгаас 20-р зууны 1959 он хүртэл
- 1959-1972 оны хоорондох үе³
- 1972 оноос өнөөг хүртэлх үе⁴


¹谢天振,《翻译研究新视野》,青岛出版社,2003

²刘和平, 扞衣立论与教学, 口译研究卷, 北京, 2005, 第三页

³ Jacobson, R. (1959) On linguistic aspects of translation буюу “Орчуулгын хэлшинжлэлийн талын тухай”

⁴ Holmes, James S. (1972/75) The Name and Nature of Translation Studies. Amsterdam “Орчуулгазүйн нэрийдэл ба мөн чанар”

Эртний уламжлалт судлал болсон Цицероны эртний герег, латин хэлний орчуулгаас 20-р зууны 1959 онд Р.Якобсоны “Орчуулга дахь хэлшинжлэлийн талын тухай” бүтээл гарсан үе хүртэл, 1959-1972 оны хоорондох үед энэхүү шинэ онолыг түшиж хөгжин байгаад 1972 онд Жеймс Холмсын “Орчуулгазүйн нэрийдэл ба мөн чанар” хэмээх бүтээл гарснаас өнөөг хүртэлх үеийг хамааруулдаг. Жеймс Холмс бүтээлдээ орчуулгазүйн судлахууны бүтцийн зургийг гаргасан байдаг билээ.



Үүнийг Тел-Авивын Их сургуулийн профессор Жидён Түри⁵ нэлээд боловсронгуй болгосон нь орчин үеийн орчуулгазүйн хөгжлийн хандлагыг тогтоож өгчээ. Тэрхүү орчуулгазүйн судлахууныг зураглаж үзүүлснийг нягталж харвал, судалгааны 3 үндсэн төвшинд хуваасан болохыг мэдэж болно. Үүнд,

Орчуулгазүй нь судалгааны гурван үндсэн төвшинтэй.:

■ 1. Орчуулгын онолын судалгаа:

- а. Орчуулгын онолын судалгаа
- б. Онцгойлж судлах төрлүүд
 - Орчуулгын төрөл (аман, бичгийн, машины орчуулга)
 - Бүс нутгийн соёл (тодорхой хэл соёлт нийгэм)
 - Хэлшинжлэл (тодорхой хэл, аман аялгуунд суурилсан судалгаа)
 - Бичиг зохиолын төрөл (уран зохиол, судар, шаштир, хууль цааз, хэвлэл мэдээллийн хэрэгслийн хэл)
 - Хугацааны холбоос (эрт, өдгөөгийн орчуулгын эх сурвалжаас харьцуулж, хэлний хөгжлийг тодруулах)

⁵ Gideon Toury, “Descriptive Translation Studies and beyond” Benjamins Translation Library, 1995.

- Онцгой сэдэв (зүйр цэцэн үг, сонгодог үлгэр, хэлц зэрэг)
- 2. Дүрслэх орчуулгазүй (Орчуулга тодорхойлох судалгаа):
 - Орчуулсан бүтээлийн судалгаа (Бэлэн орчуулга судлах)
 - Орчуулах явцад нь судлах (Орчуулах үеийн сэтгэлзүйг судлах, орчны судалгаа хийх)
 - Үүргийн судалгаа (Орчуулгыг нийгэм соёлын үүднээс судлах)
- 3. Хэрэглээний орчуулгазүй:
 - *Орчуулагч, хэлмэрч сурган бэлтгэх*
 - *Орчуулгын толь бичиг зохиох (толь бичиг ба нэр томъёоны сан бүрдүүлэх)*
 - *Орчуулгын талаар бодлого боловсруулах (Орчуулах зохиолыг сонгох, орчуулагчийг тогтоон томилох зэрэг)*
 - *Орчуулгын шүүмж*

Энэхүү орчуулгазүйн судалгааны 3 төвшингөөр эдүгээ ч гэсэн судалгааны ажлыг хийхэд гол чигээ болгон явахад боломжтой хэвээрээ байна. Нэгэнт ийм зураглалыг гаргаад өгсөн байхад, бид орчуулгын судалгааг эдгээр чиглэлээр хийгээд явбал орчуулгазүйн судалгааны цогц судлал бүрдэх мэт байгааг энд тэмдэглүүштэй байна.

Монголын орчуулгазүйн өнөөгийн байдал

Монголд орчуулгыг судлах үйл явц өнөөгийн байдлаар дараахь хоёр үед хувааж авч үзэх боломжтой байна.

1. Монгол үндэстэн нэгдэж, төр улсаа байгуулсан буюу бичгийн дурсгалд тэмдэглэж үлдсэн XIII зууны үеэс 20-р зуун хүртэлх уламжлалт орчуулгын дэг хөгжсөн үе

- *Юань улсын түүх зохиох хүрээлэн*
- *Чойжи-Одсэр зэрэг их гүүш нарын орчуулгын дэг*
- *“Мэргэд гарахын орон нэрт тогтоосон даяг оршвой”*

2. Шинэ үеийн орчуулгазүйн хөгжлийн үе

- *Судар бичгийн хүрээлэнгийн эрдэмтдийн болон нэрт сэхээтнүүдийн орчуулгазүйн ажлууд гарсан үе*
- *Орос ба төвд хэлний орчуулгын судалгаа дорвитой хөгжсөн үе*
- *Олон ургальч орчуулгазүй хөгжин буй үе*

Монгол улсад Судар бичгийн хүрээлэн байгуулагдсан үеэс манай нэрт хэл судлаач эрдэмтэд орчуулгын судалгаанд анхааран олон өгүүлэл нийтлэл гадаад дотоодод гарч эхэлсэн хийгээд “Орчуулах эрдэм” цуврал гарч орчуулгын шүүмж Б.Ринченгээс хальж олон орчуулагч-судлаач басхүү орчуулга хийнгээ орчуулгын судалгаа хийдэг болж, шүүмж судлал хөгжжээ.

Р.Гүрбазарын “Орчуулгын онол дадлагын үндэс” Л.Хүрэлбаатарын “Монгол орчуулгын товчоон” бүтээл тухайн үеийн орчуулгазүйн хөгжлийг тодорхойлсон бүтээл болсон юм. Ер нь Монгол улсад орос ба төвд хэлнээс орчуулсан орчуулгын судалгаа нэлээд дорвитой хөгжсөн гэдгийг цохон тэмдэглэмээр байгаа юм. Л.Хүрэлбаатар багштан тэргүүтэй төвд хэлний орчуулга судлаачид МУИС, шашны дээд сургуульд бий. Орос хэл судлалын нэгэн үеийн нэрт эрдэмтэд маань өрнийн хэлний орчуулгын судалгааг тэргүүлж байна. Мөн А.Шархүү профессорын “Туурвилзүй, орчуулга судлалын зарим асуудал” ном Монголын орчуулгын хамгийн сүүлийн үеийн бүтээл болж гарсан байна. Мөн орос хэлэнд суурилсан О.Адьяа багшийн дадлын томоохон бүтээлүүд, Г.Аким, Л.Чулуунбаатар, Д.Дашдаваа, Д.Гүн-Үйлс, Д.Бүрнээ, Ц.Отгонсүрэн, Ц. Базаррагчаа, Б. Чойжил нарын бүтээлүүд гарчээ. “Орчуулах эрдэм” цуврал гарч байгаад 1990-ээд оноос гарахаа больсон, “Гадаад хэлнээс орчуулах нь” цуврал гарч байгаад сүүлийн үед сураг тасарсан байснаа ойрын үед МУИС-аас “Орчуулах эрдэм” ба “Орчуулгазүй” цуврал гарч эхлэн, бие даан хөгжиж магадгүй болоод байна. Олон хэлний орчуулгын судлал мөн хөгжих тал руугаа хандлаа гэх мэтээр сүүлийн үеийн Монгол улсын орчуулгазүйн салбар нэлээд ахицтай байна.

Орчуулгазүйг хөгжүүлэх талаархи санал

Манай улсын орчуулгазүйн салбарын талаар өмнө дурдсаныг үндэслэн цаашид орчуулгазүйч нар ямар чиглэлээр ажиллах боломжтой талаар саналаа хэлье. Бид орчуулгазүйн түүхэн үйл явцыг цаг хугацааны хувьд хоёр тийш нь буюу одоогоор судалсан үеэсээ улам урагшлуулах, мөн цаашид орчин үеийн орчуулгазүйн хандлагаар илүү эрчтэй судалгаа хийвэл зохилтой байна. Монголын орчуулгазүйг 13-р зуунаас өмнөх үеийн судалгаанд хандуулах, үүнд, хятадын түүхэн сурвалжууд ба хиргис, түрэг, хятаны үеийн орчуулгын түүхэнд холбогдох мэдээ занги их буйг сурвалжлан тодруулж, судалгааны эргэлтэд оруулах, хоёрт өнөөгийн орчуулгазүйн хөгжлийн хандлагыг даган судалгаа хийх, сургахдаа дээр өгүүлсэн Жидён Түри-гийн “орчуулгазүйн тодорхойлолт” дахь орчуулгазүйн 3 төвшингийн судалгааг ончтой хуваарилан хийгээд явбал дэлхийн хөгжилтэй зэрэгцэн явахаар юм болов уу гэсэн санаа байгаа юм.

Эцэст нь тэмдэглэхэд, энэ салбарт хийгүүштэй ажлууд бас байна. Үүнд:

- Эх хэлний боловсрол эзэмшүүлэх ажлыг гадаад хэл сургахтай эн тэнцүү хийх, орчуулгаар дамжин орж ирж буй гадаад соёлын утга шингэмэл үг хэллэгийг бодлоготойгоор цэгцлэх,
- Орчуулгазүй хэмээх шинжлэх ухааны хөгжлийн төвшин, орчуулгын онолын бүтээлүүдтэй танилцах, харьцуулах ч хэрэгцээ байна.
- Улсын орчуулагч, хэлмэрч мэргэжилтэн бэлдэх сургалтын ажлыг чанартай хийх, давтан сургалт ч хийж болох.
- Хийж чадаж байсан нэр томъёо судлалын ажлыг сэргээх
- Орчин үеийн технологийн хөгжлийн үр дүн болох цахим орчуулга, машин орчуулгын хөгжилтэй зэрэгцэн энэ талын судалгааг хоцролгүй хийж явах
- Орчуулгын шүүмж судлалыг эргэн сэргээж, ариутган хянаагүй, тааруухан орчуулгыг багасгах ажлыг хийх
- Хэвлэл мэдээллийн хэрэгслийн орчуулга, залуусын хэл ярианы соёлыг дээшлүүлэх ажил хийгүүштэй байна.